



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Г 2023 оныг "Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил" болгон зарлах тухай

"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.7.4, 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ГТХЗНТ" УТҮГ үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан төвийн хэмжээнд 2023 оныг "Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил" болгон зарласугай.

2. "Бүтээн байгуулалт, шинэ технологи нэвтрүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан төвийн 2023 оны гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийт ажилтанд даалгасугай:

2.1/ төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын ажлын зураг болон барилга угсралтын ажлын даалгавар боловсруулж батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, төслийн барилгын ажлыг эхлүүлэх;

2.2/ төмөр замын инженер-ирээдүй дурсгалын цогцолборын төслийг боловсруулах

2.3/ 10 жилийн ойн нэрэмжит галт тэрэг аялуулах;

2.4/ төмөр замын салбарын бүтээн байгуулалтыг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах; ✓

2.5/ галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сарын аян зохион байгуулах; ✓

2.6/ ШУТИС-тай хамтран ачааны галт тэрэгний тэргэнцэрт ST LIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмж суурилуулж туршилт зохион байгуулах, үр дүнг танилцуулах;

2.7/ суурь бүтэц эзэмшигчийн сэлгээний зүтгүүрт FMB640 маркийн төхөөрөмж суурилуулж туршилт зохион байгуулах, үр дүнг танилцуулах;

2.8/ ОХУ-ын Иркутскийн Зам харилцааны улсын их сургуулийн 2023-2024 оны хичээлийн магистрын сургалтад салбарын инженерүүдийг хамруулах;

2.9/ ОХУ-ын Иркутскийн Зам харилцааны улсын их сургуульд "Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалт", "Зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүнийг үр дүнтэй ашиглах асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд", "Уулзваргүй зам барих, ашиглах, орчин үеийн технологи нэвтрүүлж замын ажлын чанарыг сайжруулах", "Цахилгаан сүлжээний ашиглалтын зохион байгуулалт", "Төмөр замын автоматжуулалт ба телемеханикийн

161220104

микропроцессорын системийн техникийн ашиглалт” чиглэлээр салбарын инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

2.10/ БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “CIAT” дадлагажих хөтөлбөрийн сургалтад салбарын ажилтнуудыг хамруулах.

3. Тушаалын 2-т заасан арга хэмжээг нэгжийн гүйцэтгэлийн болон сарын ажлын төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хариуцах ажилтан, хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан тусгаж үе шаттай хэрэгжүүлж ажлын уялдаа холбоог хангаж ажиллахыг Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс (Д.Төгсжаргал), Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс (Ц.Оюунбат)-т тус тус даалгасугай.

4. Жилийн хүрээнд зохион байгуулсан, шийдвэрлэсэн ажлын явц, гүйцэтгэл, үр дүнг тухай бүр танилцуулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс (Д.Төгсжаргал), Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс (Ц.Оюунбат)-т тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ